БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БНА-2019/112/СТА-ТШЗ


Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Аудитор: Ж.Өсөхбаяр

Утас: 99890393 Цахим хаяг: usukhbayar_j@yahoo.com

Цахим хуудас: www.audit.mn


Баянхонгор
2019 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1 Аудитын гэрчилгээ ..... 2
2 Аудитын тайлан ..... 4
2.1. Оршил ..... 4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ..... 4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ..... 4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ..... 5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ..... 6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ..... 6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ..... 7
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ..... 7
2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..... 7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ..... 7
2.11. Шилэн дансны мэдээлэл ..... 8
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга ..... 8
2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ..... 8
3 Аудит хийсэн санхүүгийн тайлан ..... 9
3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 9
3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 10
3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 11
3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 12
3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 12

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

# 1 Аудитын гэрчилгээ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail; bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНОР АЙМГИЙН
ХӨГЖИМТ ДРАМЫН ТЕАТРЫН
ДАРГА Б.ПҮРЭВДАГВА ТАНАА

2019.02.25 № 2/122

танай ______________-ны №______________-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл,санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын

E:\Usukhuu\STA-2019\10.Хөгжимт драмын театр\3.Тайлагнал\ХДТ_гэрчилгээ.docx

2519230

систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

E:\Usukhuu\STA-2019\10.Хөгжимт драмын театр\3.Тайлагнал\ХДТ_гэрчилгээ.docx

# 2 Аудитын тайлан

### 2.1. Оршил

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Дарга Б.Пүрэвдагва-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 23-наас 2019 оны 02 дугаар сарын 25–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 05 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театр нь “Хүний эрхийг дээдлэн тэдний соёл, оюуны эрэлт хэрэгцээг чанартай уран бүтээл, ажил үйлчилгээгээр хангаж, ардын уламжлалт урлагийг орчин үеийн болон дэлхийн сонгодог урлагтай хослуулан хөгжүүлж, төрөөс Соёлын талаар баримтлах бодлого, Монгол Улсын Соёлын тухай хууль, морин хуур, уртын дуу, бий биелгээ, үндэсний хөтөлбөрүүд, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, Нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилт тавин “Чанартай бүтээл-Соёлтой үйлчилгээ уриан дор үйл ажиллагаа явуулахад оршино" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Дэлхийн болон Монголын сонгодог уран бүтээлийг төв халхын ёс заншил, дэг жаяг, угсаатны соёлтой холбон орон нутгийн онцлогт уялдуулан дуулалт болон сонгодог жүжиг тавьж, улсын уралдаан зохион байгуулах

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг

баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

**2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 879070.1 мянган төгрөг бөгөөд түүний *2* хувь болох *17581.4* мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

**2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд алдаа, зөрчилтэйд тооцох асуудал гараагүй болно.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

**2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Байхгүй

**2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 721237.9 мянган төгрөгийн

төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 3.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 720008.7 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь 2018 онд 696237.9 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулан 1229.2 мянган төгрөг хэмнэгдсэнтэй холбоотой байна.

### 2.11. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### 2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### 2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

# 3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **185,118,787.01** | **198,040,011.01** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 00.01 | 00.01 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 00.01 | 00.01 |
| **3121** | **Төгрөг** | 00.01 | 00.01 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 00.01 | 00.01 |
| **33** | **АВЛАГА** | 932,500.00 | 932,500.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 932,500.00 | 932,500.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 184,186,287.00 | 197,107,511.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 184,186,287.00 | 197,107,511.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,437,515.00 | 3,212,135.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 16,378,235.00 | 20,689,800.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 80,000.00 | 80,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 165,290,537.00 | 173,125,576.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,020,800,393.30** | **1,136,140,964.28** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,020,800,393.30 | 1,136,140,964.28 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,001,926,976.60 | 917,555,714.24 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,735,207,132.00 | 1,592,901,608.66 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -962,633,422.86 | -833,982,820.43 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 48,036,000.00 | 12,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -44,786,000.00 | -10,250,000.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 306,129,884.00 | 306,409,884.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -191,068,540.36 | -237,359,640.84 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 154,637,627.00 | 174,332,627.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -110,499,219.87 | -127,786,544.15 |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 61,000,000.00 | 37,000,000.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 6,250,000.00 | 6,250,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -4,627,083.31 | -6,250,000.00 |
| 39217 | Ном | 4,280,600.00 | 4,290,600.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 18,873,416.70 | 218,585,250.04 |
| 39301 | Програм хангамж | 650,000.00 | 650,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -650,000.00 | -650,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 41,637,355.00 | 245,187,355.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -22,763,938.30 | -26,602,104.96 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,205,919,180.31** | **1,334,180,975.29** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,205,919,180.31** | **1,334,180,975.29** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,205,919,180.31 | 1,334,180,975.29 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 745,138,163.91 | 945,688,163.91 |
| 51101 | Өмч: - төрийн | 745,138,163.91 | 945,688,163.91 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -44,836,454.29 | -116,824,659.31 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -44,836,454.29 | -44,836,454.29 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -71,988,205.02 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 505,617,470.69 | 505,317,470.69 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,205,919,180.31** | **1,334,180,975.29** |

## 3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **547,594,860.00** | **807,081,947.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **22,584,300.00** | **72,587,856.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 22,584,300.00 | 72,587,856.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 22,584,300.00 | 72,587,856.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 20,814,300.00 | 25,010,300.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,770,000.00 | 47,577,556.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **53,276,960.00** | **38,256,191.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 471,733,600.00 | 696,237,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 18,939,156.00 | 12,078,500.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 6,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 12,000,000.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 6,939,156.00 | 6,078,500.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 32,245,000.00 | 19,695,000.00 |
| 133003 | Хөрөнгийн | 32,245,000.00 | 19,695,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 2,092,804.00 | 6,482,691.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 2,092,804.00 | 6,482,691.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **542,291,905.18** | **847,922,233.07** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **542,291,905.18** | **847,922,233.07** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 529,103,805.18 | 832,329,220.65 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 297,918,486.00 | 428,092,879.00 |
| 210101 | Үндсэн цалин | 295,825,682.00 | 428,092,879.00 |
| 210102 | Нэмэгдэл | 2,092,804.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 32387009.00 | 51104672.08 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,387,009.00 | 51,104,672.08 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 97,192,973.00 | 199,429,898.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,372,331.00 | 6,051,622.00 |
| 210302 | Түлш, халаалт | 89,320,000.00 | 188,573,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,500,642.00 | 4,805,276.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5279363.00 | 7670329.50 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,759,590.00 | 2,491,640.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,380,000.00 | 3,516,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,010,298.00 | 1,413,089.50 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 129,475.00 | 249,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 148,275.00 | 00.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 148,275.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,822,245.00 | 1,600,665.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,822,245.00 | 1,600,665.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,343,030.00 | 1,482,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 272,500.00 | 1,482,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 2,070,530.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 11,181,090.00 | 31,742,711.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,831,670.00 | 31,308,931.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 137,900.00 | 137,900.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 130,000.00 | 177,800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 00.00 | 22,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 00.00 | 96,080.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 81,520.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 79,831,334.18 | 111,206,066.07 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 79,831,334.18 | 111,206,066.07 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 13,188,100.00 | 15,593,012.42 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 13,188,100.00 | 13,243,491.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 00.00 | 6,482,691.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 13,188,100.00 | 6,760,800.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 1,239,521.42 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 1,239,521.42 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 1,110,000.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 1,110,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **5,302,954.82** | **-40,840,286.07** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 1,101,854.80 | 31,147,918.95 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 1,101,854.80 | 31,147,918.95 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -1,101,854.80 | -31,147,918.95 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **4,201,100.02** | **-71,988,205.02** |

## 3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **513,579,860.00** | **739,809,391.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **20,814,300.00** | **25,010,300.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 20,814,300.00 | 25,010,300.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 20,814,300.00 | 25,010,300.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 20,814,300.00 | 25,010,300.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **492,765,560.00** | **714,799,091.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 471,733,600.00 | 696,237,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 18,939,156.00 | 12,078,500.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 6,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 12,000,000.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 6,939,156.00 | 6,078,500.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 2,092,804.00 | 6,482,691.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 2,092,804.00 | 6,482,691.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **513,579,860.00** | **739,809,391.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **513,579,860.00** | **739,809,391.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **500,391,760.00** | **724,216,378.58** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 303,378,486.00 | 428,423,616.66 |
| 210101 | Үндсэн цалин | 301,285,682.00 | 428,423,616.66 |
| 210102 | Нэмэгдэл | 2,092,804.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 32,387,009.00 | 50,773,934.42 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,387,009.00 | 44,123,780.92 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 3,887,259.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 2,762,894.50 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 97,192,973.00 | 199,429,898.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,372,331.00 | 6,051,622.00 |
| 210302 | Түлш, халаалт | 89,320,000.00 | 188,573,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,500,642.00 | 4,805,276.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,874,298.00 | 4,331,469.50 |
| 210401 | Бичиг хэрэг | 310,000.00 | 571,480.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,233,000.00 | 1,655,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,050,298.00 | 1,413,089.50 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 31,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 280,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 281,000.00 | 380,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 333,750.00 | 340,700.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 333,750.00 | 340,700.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,224,000.00 | 4,325,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,224,000.00 | 4,325,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,211,656.00 | 1,482,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 272,500.00 | 1,482,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 6,939,156.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 52,789,588.00 | 35,109,260.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 21,138,437.00 | 34,109,840.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 137,900.00 | 137,900.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 130,000.00 | 177,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 00.00 | 22,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 00.00 | 661,720.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 496,620.00 | 00.00 |
| 210818 | Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/ | 30,886,631.00 | 00.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **13,188,100.00** | **15,593,012.42** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 13,188,100.00 | 13,243,491.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 00.00 | 6,482,691.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 13,188,100.00 | 6,760,800.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 1,239,521.42 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 1,239,521.42 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 1,110,000.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 1,110,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **30,886,631.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.01 | 00.01 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.01 | 00.01 |

## 3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| D01 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **745,138,163.91** | **505,617,470.69** | **-44,836,454.29** | 1,205,919,180.31 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **745,138,163.91** | **505,617,470.69** | **-44,836,454.29** | 1,205,919,180.31 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -300,000.00 | 00.00 | -300,000.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 200,550,000.00 | 00.00 | 00.00 | 200,550,000.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -71,988,205.02 | -71,988,205.02 |
| D09 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **945,688,163.91** | **505,317,470.69** | **-116,824,659.31** | 1,334,180,975.29 |

## 3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/ төгрөгөөр /**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 700,568,000.00 | 700,121,695.00 | 721,237,900.00 | 720,008,678.58 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 700,568,000.00 | 700,121,695.00 | 721,237,900.00 | 720,008,678.58 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 668,078,400.00 | 667,642,095.00 | 714,477,100.00 | 713,247,878.58 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 403,983,100.00 | 403,713,700.00 | 428,774,100.00 | 428,423,616.66 |
| 210101 | Үндсэн цалин | 403,983,100.00 | 403,713,700.00 | 428,774,100.00 | 428,423,616.66 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 46,319,300.00 | 46,319,200.00 | 51,452,800.00 | 50,773,934.42 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 46,319,300.00 | 46,319,200.00 | 51,452,800.00 | 44,123,780.92 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 00.00 | 00.00 | 3,887,259.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 00.00 | 00.00 | 2,762,894.50 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 167,094,900.00 | 167,039,197.00 | 199,464,600.00 | 199,429,898.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,772,000.00 | 6,090,751.00 | 6,053,000.00 | 6,051,622.00 |
| 210302 | Түлш, халаалт | 156,484,300.00 | 156,310,000.00 | 188,573,000.00 | 188,573,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,838,600.00 | 4,638,446.00 | 4,838,600.00 | 4,805,276.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,867,800.00 | 3,861,536.00 | 4,337,800.00 | 4,331,469.50 |
| 210401 | Бичиг хэрэг | 512,000.00 | 511,120.00 | 512,000.00 | 571,480.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,655,400.00 | 1,655,400.00 | 1,655,400.00 | 1,655,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,316,000.00 | 1,310,616.00 | 1,500,000.00 | 1,413,089.50 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 00.00 | 00.00 | 31,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 00.00 | 286,000.00 | 280,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 384,400.00 | 384,400.00 | 384,400.00 | 380,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 7,241,200.00 | 7,239,800.00 | 340,700.00 | 340,700.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 7,241,200.00 | 7,239,800.00 | 340,700.00 | 340,700.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,525,500.00 | 4,505,845.00 | 4,325,500.00 | 4,325,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,525,500.00 | 4,505,845.00 | 4,325,500.00 | 4,325,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,493,200.00 | 1,462,500.00 | 1,493,200.00 | 1,482,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,493,200.00 | 1,462,500.00 | 1,493,200.00 | 1,482,000.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 33,553,400.00 | 33,500,317.00 | 24,288,400.00 | 24,140,760.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 32,100,500.00 | 32,047,417.00 | 23,135,400.00 | 23,141,340.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 137,900.00 | 137,900.00 | 137,900.00 | 137,900.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 94,000.00 | 94,000.00 | 80,000.00 | 00.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 235,000.00 | 235,000.00 | 235,100.00 | 177,800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 37,600.00 | 37,600.00 | 37,600.00 | 22,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 286,500.00 | 286,500.00 | 500.00 | 00.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 00.00 | 00.00 | 661,900.00 | 661,720.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 661,900.00 | 661,900.00 | 00.00 | 00.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 32489600.00 | 32479600.00 | 6760800.00 | 6760800.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 32,489,600.00 | 32,479,600.00 | 6,760,800.00 | 6,760,800.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 13,188,100.00 | 13,188,100.00 | 6,760,800.00 | 6,760,800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 19,301,500.00 | 19,291,500.00 | 00.00 | 00.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 700,568,000.00 | 700,121,695.00 | 721,237,900.00 | 720,008,678.58 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 676,130,500.00 | 674,920,795.00 | 696,237,900.00 | 694,998,378.58 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 676,130,500.00 | 674,920,795.00 | 696,237,900.00 | 694,998,378.58 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 24,437,500.00 | 25,200,900.00 | 25,000,000.00 | 25,010,300.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 24,437,500.00 | 25,200,900.00 | 25,000,000.00 | 25,010,300.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **00.00** | **00.00** | 00.00 | 00.01 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **00.00** | **00.00** | 00.00 | 00.01 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 60.00 | 60.00 | 60.00 | 60.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 49.00 | 49.00 | 49.00 | 49.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 10.00 | 10.00 | 10.00 | 10.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **60.00** | **60.00** | **60.00** | **60.00** |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн йилчилгээний албан хаагч (ТҮСУ) | 12.00 | 12.00 | 12.00 | 12.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 48.00 | 48.00 | 48.00 | 48.00 |